



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10, 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал Б.Отгонсүхтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Б.Отгонсүхтэй Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн тул гүйцэтгэх захирал Б.Отгонсүхэд хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4. Б.Отгонсүхэд олгох урамшууллыг холбогдох зардлаас гаргахыг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Ерөнхий нягтлан бодогч П.Амарцэцэгт зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001325

11-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн
6/ дугаар тогтоолын хавсралт

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛД
2023 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Захирлын нэр	Цэвэр ашиг (мян.төг)	Цэвэр ашгийн дүнгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал (мян.төг)	Урамшуулал тооцох цэвэр ашиг (мян.төг)	Олгох урамшууллын хэмжээ (мян.төг)
1	"Монголын төмөр зам" ТӨХК	Б.Отгонсүх	12,904,340.89	3,376.07	9,528,268.89	26,905,650.00 (хорин зургаан сая есөн зуун таван мянга зургаан зуун тавин төгрөг)